# Хариуцлагатай нүүдэлчдийн бэлтгэсэн малын гаралтай бүтээгдэхүүний өртгийн сүлжээний мөшгөх тогтолцоог сайжруулах

| | |
|---|---|
| Төслийн нэр: | Байгаль орчин аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөл |
| Гүйцэтгэгч | *МОНГОЛЫН БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО, МОНГОЛЫН НООС НООЛУУРЫН ХОЛБОО* |

ГАРЧИГ

Summary ... 3
Оршил ... 4
Төслийн зорилго ... 4
Төслийн зорилт ... 4
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ОНЦЛОГ ... 5
Цагаан-овоо суманд нэвтрүүлж буй байдал ... 7
ХОЁРДУГААР БҮЛЭГ: "ХАРИУЦЛАГАТАЙ НҮҮДЭЛЧИД" БЭЛЧЭЭРИЙН МАА-Н ЗОХИСТОЙ ДАДЛЫН СТАНДАРТЫГ ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР СУМАНД НЭВТРҮҮЛЖ БУЙ БАЙДАЛ ... 9
ДҮГНЭЛТ ... 147
Ноос, ноолуурын баталгаажуулалт болон тогтвортой нийлүүлэлтийг ихэсгэж, олон улсад гаргах орон нутгийн чадавхын талаарх зөвлөмж ... 15

## Summary

The Responsible Nomads Code of Practice (RNCP) was approved in 2020 by the Mongolian National Authority Accreditation Center as the national standard. The Mongolian National Federation of Pasture User Groups (MNFPUG) was therefore authorized as an agency to issue the certificate for sustainable practice for cooperatives. In 2023, MoFALI appointed the MNFPUG as the professional certification organization and concluded an agreement to act executing organization of the raw material traceability system (RMTS).

To comply with the goals to implement the RNCP, the MNFPUG operates in two ways: (i). ensure implementation of the RNCP in a sustainable manner; and (ii). auditing the certified cooperatives how the evaluation of the implementation state of RNCP promotes to improve range conditions, animal health, breeding, animal welfare and quality of animal raw materials. The RNCP streamlines the opportunity to livestock producers to with the final buyers and processors without any non-business mediators (the changers) and sell their with premium prices.

The project, based on MNS 6891:2020 "Responsible Nomads Code of Practice," focuses on promoting sustainable production practices and enhancing the livelihoods of herders in Mongolia. Five manuals were created for herders, and extensive training involving 85 government representatives and 380 herders was conducted, doubling the participant numbers. Additionally, two pasture user groups were formed, working on rangeland use agreements and regulations in Dashbalbar soum.

In Dashbalbar soum, the Sevsuul Jarahain Bulag Agricultural Cooperative was established, becoming a member of the Mongolian National Standard Cooperative. Notably, 10 tons of certified cashmere from Dashbalbar soum are prepared for international markets by Snow Field LLC.

The successful implementation of the "Responsible Nomads Code of Practice" for sustainable production has yielded significant benefits for the Dornod Galuut Cooperative of Tsagaanovoo Soum. This cooperative was able to supply 737 sheep and 382 cattle to the Mongolian National Standard Cooperative at premium prices. As a direct result, the income of the herders associated with this cooperative has witnessed a notable increase value add by 57,1 million tugrik. This outcome underscores the positive impact of sustainable practices on both economic prosperity and the overall well-being of herders within the region.

To ensure complete traceability in the cashmere value chain, Digital Medic LLC has been contracted to develop a cashmere factories system as part of the project. These initiatives collectively aim to foster sustainable practices and economic growth within the Mongolian herding and cashmere production industry in whole value chain.

## Оршил

“Хариуцлагатай нүүдэлчид” Бэлчээрийн МАА-н зохистой дадлын стандарт нь 2020 онд үндэсний хэмжээний стандарт болж батлагдсан. МБАНХ нь энэ стандартын дагуу баталгаажуулалт хийх тохирлын гэрчилгээ олгох эрхийг 2022 Монгол улсын Стандарт хэмжил зүйн газраас авсан.

МБАНХ нь 2023 онд ХХААХҮ-ийн сайдын тушаалаар мэргэшсэн байгууллагаар томилуулж ХХААХҮ-яамтай “Хариуцлагатай нүүдэлчид” тохирлын гэрчилгээг олгох, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний мөшгөх системийг ашиглахаар гэрээ байгуулан ажиллаж байна.

“Хариуцлагатай нүүдэлчид” стандартаар баталгаажуулж гэрчилгээ олгосноор малчид малын гаралтай бүтээгдэхүүний өндөр үнээр зах зээлд нийлүүлэх, түүгээр дамжуулан бэлчээрийн ачааллыг бууруулж бэлчээр сайжруулах боломж бүрдэх юм. Энэ стандарт нь дотроо таван үндсэн хэсэгтэй. Үүнд:

- Бэлчээр зохион байгуулалт
- Малын үржил селекци
- Малын тавлаг байдал
- Малын эрүүл мэнд
- Малын гаралтай түүхий эдийн чанар гэсэн таван бүрэлдэхүүн хэсгийг шингээсэн цогц стандарт юм.

Тиймээс энэ стандартыг хэрэгжүүлэхийн тулд тодорхойлон, боломжит малдын хоршоотой ажиллаж байна. Үүн дээр тулгуурлан төслийн хүрээнд хийгдэх ажлын хүрээг нарийвчлан гаргаж байна.

## Төслийн зорилго

Төслийн зорилго нь хариуцлагатай нүүдэлчид МАА-н зохистой дадлын стандартыг Дорнод аймгийн Дашбалбар, Цагаан-Овоо сумын бэлчээрийн төлөв байдлыг харгалзан аль нэг багийн малчдад стандартыг таниулан сурталчлах, стандартыг зохистой дадлуудыг нэвтрүүлэх мөшгөх тогтолцооны системийг сайжруулах замаар малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний борлуулалт, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино. Ингэснээр малчид мал, мах болон малын гаралтай бүтээгдэхүүнийг (ноос, ноолуур) зах зээлд тогтмол өндөр үнээр нийлүүлэх боломж бүрдэж бэлчээрийн ачаалал буурна.

## Төслийн зорилт

“Хариуцлагатай нүүдэлчид” бэлчээрийн МАА-н зохистой дадлын стандартыг Цагаан-Овоо, Дашбалбар сумын аль нэг багийн хэмжээнд загвар байдлаар нэвтрүүлсэн байна.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ОНЦЛОГ

## Дашбалбар сумын МАА-н төлөв байдал

Сумын нутаг дэвсгэр 871315 га, үүнээс бэлчээрийн газар 745264 га, хадлангийн талбай 35099 га байна. Нутгийн тогтцын хувьд нь зүүн тийшээ налуу, өндөр газар нь Хар өндөр (1131 м), Улз голын дагуу намхан, жижиг уулс толгод бүхий газар нутагтай.

2014 оноос хойш хонь, ямааны тоо толгой хурдацтай өссөн байна. Бусад малын тоо харьцангүй тогтмол байна (График 1).

*График 1. Дашбалбар сумын малын тооны өсөлт*




Бэлчээрийн төлөв байдлаас харахад нийт бэлчээрийн 33 хувь нь дундаас хүчтэй доройтсон, 60 хувь нь бага зэрэг доройтсон, 6 хувь нь соргог байна.

*Зураг 1. Дашбалбар сумын бэлчээрийн төлөв байдал*



*Хүснэгт 1. Дашбалбар сумын бэлчээрийн сэргэх чадавхийн ангилал*

| Судалгааны цэгийн нэр | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|
| **Хайчийн булаг** | | IV | II | II | II | Зохистой ашиглалтыг нэвтрүүлсэн сайжирч буй бэлчээр |
| **Чух** | | IV | III | I | III | Зохистой ашиглалтыг нэвтрүүлсэн сайжирч буй бэлчээр |
| **Угтам хошууны урд** | | II | II | I | II | Зөв ашиглалттай соргог бэлчээр |
| **Уванхай модны ар хөндий** | | III | III | IV | III | Зохистой ашиглалтыг нэвтрүүлсэн сайжирч буй бэлчээр |
| **Мужлан** | | III | III | III | III | Зохистой ашиглалтыг нэвтрүүлсэн сайжирч буй бэлчээр |
| **Тахилгат** | | II | II | I | II | Зөв ашиглалттай соргог бэлчээр |
| **Гэрт** | | IV | II | I | II | Зохистой ашиглалтыг нэвтрүүлсэн сайжирч буй бэлчээр |
| **Рашаан** | | II | II | I | II | Зөв ашиглалттай соргог бэлчээр |
| **Улз** | | II | II | I | II | Зөв ашиглалттай соргог бэлчээр |
| **Нарст** | | IV | II | II | II | Зохистой ашиглалтыг нэвтрүүлсэн сайжирч буй бэлчээр |
| **Харзат** | | II | II | I | II | Зөв ашиглалттай соргог бэлчээр |
| **Тарвагат** | | I | II | II | II | Зөв ашиглалттай соргог бэлчээр |
| **Даагай** | | III | III | IV | IV | Бэлчээр хүчтэй доройтож байгаа тул ашиглалтын горим, ачааллыг өөрчлөх шаардлагатай |
| **Өвөр харзат** | | III | III | I | I | Зохистой ашиглалтыг нэвтрүүлсэн сайжирч буй бэлчээр |
| **Мардай** | | III | III | IV | IV | Бэлчээр хүчтэй доройтож байгаа тул ашиглалтын горим, ачааллыг өөрчлөх шаардлагатай |

Хүснэгт 2-оор Дашбалбар сумын МАА-д тулгараад байгаа асуудал, сумын давуу тал болон боломжуудыг тусган харууллаа. Үүнээс харахад маш олон асуудал байгаа хэдий ч “Хариуцлагатай нүүдэлчид” стандартыг нэвтрүүлснээр малын гаралтай бүтээгдэхүүний чанар, үнэлэмжийг нэмэгдүүлэх боломжтой харагдаж байна ( 1).

*Хүснэгт 2. Дашбалбар сумын өнөөгийн нөхцөл байдал*

| /д | Сул тал | Давуу тал |
|---|---|---|
| **1** | Гадны мал ихээр орж ирэх болсон нь бэлчээр муутгаж, хадлан авах боломжгүй болгож байна.<br>Малчид нүүдэл сэлгээ хийх нь багасаж илүү суурьшмал хэлбэр лүү шилжиж байна.<br>Зуны улиралд зарим айл өвөлжөөний бэлчээр рүү малаа оруулж идүүлж байна<br>Сүүлийн жилүүдэд ердийн хөсөг ашиглахаа больж мотоцикл, машинаар нүүдэл хийх, мал хариулах зэргээр бэлчээрт сөхөн нөлөө үзүүлж байна<br>Хоршооны муу туршлага бий болсноос малчид хоршиж хамтрахад болгоомжилж байна.<br>Малын тоо нэмэгдэж байгаа нь бэлчээрийг доройтуулах эрсдэлийг бий болгож байна. Нэгдүгээр багт бэлчээрийн даац хэтэрсэн,<br>Мэргэжлийн мал зүйч сумдад байхгүй<br>Удам гарвал тодорхойгүй эцэг малыг үржилд их ашиглаж байгаа<br>Үржлийн малд хяналт байхгүй<br>2021 онд үхрийн арьс товруутах, цэцэг, шүлхий өвчин гарч байсан.<br>Хувийн мал эмнэлэг үржлийн (МЭҮН) 4 нэгжтэй. Малын эмчийн хүрэлцээ муу байна. Залуу эмч нар суманд ажиллах сонирхолгүй байна<br>2021 онд үхрийн арьс товруутах, цэцэг, шүлхий өвчин гарч байсан.<br>Өмнө халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх ажлыг жилд олон удаа хийж байгаагүй<br>Үхрийн арьс товруутах өвчин гарахад тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах туршлага байгаагүй. Мөн МЭЕГ-аас өвчтэй малыг устгах, устгахгүй гэх | Бэлчээр нь харьцангуй соргог төлөв байдалд байна,<br>Сумын ихэнх малчдаас жил бүр Снөөв Фийлдэс ХХК ноолуурыг авч хэвшсэн байна,<br>Хариуцлагатай нүүдэлчид стандартыг нэвтрүүлэх сонирхлоо ихэнх нь илэрхийлж байна.<br>Ил задгай нуур, цөөрөм, хужир мараа элбэг<br>Ихэвчлэн байгалийн хадлан бэлтгэж хангалттай хэмжээнд нөөцөлдөг<br>Малаас авч байгаа өнөөгийн ашиг шимийн гарц стандартад заасан үзүүлэлтээс илүү байна.<br>МЭҮН нь ажил үйлчилгээгээ цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэж байгаа талаар сумын ЗДТГ-аас тодорхойлж байсан.<br>2022 оны 8 дугаар сарын байдлаар мал, амьтны халдварт, гоц халдварт өвчин бүртгэгдээгүй тайван байна.<br>Сумын мал эмнэлгийн тасаг болон МЭҮН-үүд 3 дахь удаагийн үзлэгт мал сүргээ бүрэн хамруулсан байна.<br>Шүлхий, үхрийн арьс товруутах, цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад мал, сүргээ бүрэн хамруулсан<br>Өнгөрсөн 3 жил аймгийн хэмжээнд зуншлага сайхан болж үхрийн яс сөнөрөх өвчний гаралт бага байгаа талаар аймгийн МЭГ-аас мэдээлж байсан. Аймгийн хэмжээнд тус өвчнийг газар дээр нь оношлох зөөврийн цусны биохимийн аппараттай болсон.<br>Гэрээт малын эмчээс шаардлагатай эм, тариа авдаг.<br>Мал эмнэлгийн цахим нэгдсэн системд холбогдсон.<br>Мал, амьтны шилжилт хөдөлгөөн болон түүхий эдэд QR код бүхий гарал үүслийн бичгийг цаг |

| | |
|---|---|
| зааварчилгаа маш их удаж ирсэн. Үүнээс болж халдвар тархах гол шалтгаан болсон.<br>Яс сөнөрөх өвчнийг оношлох, эмчлэх арга зүйгүй байхад жил олон тооны мал тус өвчнөөр хорогдож байсан<br>Малчид малын эмийн зөв зохистой хэрэглэх тал дээр ойлголт муутай байна.<br>Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ авахдаа малын эмчид үзүүлэхгүйгээр авдаг<br>Ноолуур болон ноосоо өнгөөр нь болон насаар нь ангилан ялгаж зах зээлд борлуулдаггүйг.<br>Түүхий эдийн буюу малчдын хоршоо байхгүйгээс түүхий эдээ бөөн дүнгээр үнэтэй өгөх боломжийг алдаж байна.<br>Ноос, ноолуураас өөр малын гаралтай түүхий эдийн орлого муу. | алдахгүй олгох боломж бүрдсэн. Мөн мал эмнэлгийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус арга хэмжээг цахим бүртгэлийн системээр дамжуулан малчны хотонд хүрч үйлчилж байна<br>Ноолуурын чанар сайн буюу нарийн микронтой ноолууртай. Ноос цагаан өнгийн, нарийн ноостой. Дашбалбар сум нь ноолуураа байнга Сноов фийлдс ХХК-д тогтмол нийлүүлж сурсан. |

## Цагаан-овоо суманд нэвтрүүлж буй байдал

Сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 650200 га, үүнээс бэлчээрийн газар 353215 га, хадлангийн талбай 63380 га, тариаланд тохиромжтой газар 4046 га талбай байна.

Эх газрын эрс тэс уур амьсгалтай. 1-р сарын дундаж температур -18°C, 7-р сард +20°C, жилд дунджаар 200-250 мм тунадас унадаг. Хэрлэн гол, Галуут, Хөөвөр, Гүн цэнгэлэг гэх мэт нуур тойромтой. Нугын үлдмэл, нимгэн, мараалаг хар хүрэн хөрстэй. Хойт хэсгээр үетэн, алаг өвс, өмнөд хэсгээр харгана, жижиг бутлаг, үетэн, хиаг, хялгана зонхилсон ургамалтай, хусан төгөл, зураатай. Бор гөрөөс, чоно, үнэг, хярс, мануул, тарвага гэх мэт ан амьтад, хээрийн ба усны шувуудтай.

Нийт малын тоо 2000 оноос хойш эрчимтэй өссөн. Тэр дундаа ямааны тоо хоёр дахин өссөн. 2022 оны байдлаар нийт малын тоо 320,049 болтлоо өссөн (**Error! Reference source not found.**).

*График 2. Цагаановоо сумын малын тоо, толгойн өсөлт*




Бэлчээрийн төлөв байдлын судалгаанаас харахад нийт бэлчээрийн 58 хувь нь дунджаас хүчтэй доройтсон, 33 хувь нь бага зэрэг доройтсон байна (зураг 2).

## Малын тоо хэт өсөлттэй холбоотойгоор нийт бэлчээрийн 18 хувь нь хүчтэй доройтсон, 79 хувь нь дунд зэрэг доройтсон байна (Map 1).

Сумдын бэлчээрийн төлөв байдлаас харахад бэлчээр ихээхэн доройтож байгаа нь харагдаж байна.

*Мар 1. Цагаановоо сумын бэлчээрийн төлөв байдал*



# ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХАРИУЦЛАГАТАЙ НҮҮДЭЛЧИД” БЭЛЧЭЭРИЙН МАА-Н ЗОХИСТОЙ ДАДЛЫН СТАНДАРТЫГ ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР СУМАНД НЭВТРҮҮЛЖ БУЙ БАЙДАЛ

## Хүрэх үр дүн 1. Дорнод аймгийн Дашбалбар, Цагаан-овоо сумaнд загвар хоршоо бий болгож Хариуцлагатай нүүдэлчид бэлчээрийн МАА-н зохистой дадлын стандартын талаар сургалт явуулах

Сургалт явуулахаас өмнө сургалтад шаардлагатай 5 төрлийн гарын авлагыг бэлтгэлээ. Үүнд: “MNS 6891:2020 Хариуцлагатай нүүдэлчид бэлчээрийн мал аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлагууд” стандартын талаар малчдад зориулан гарын авлага, болон хялбаршуулан таниулах брошюр болон малчны өврийн дэвтэр 600 ширхэгийг бэлтгэн хэвлүүлэн сургалтдаа ашигласан. Хэвлүүлсэн гарын авлага, брошюр, тарааж өгөх материалыг эх хувиар нь тайланд хавсаргав.

Үүнд:

1. “MNS 6891:2020 Хариуцлагатай нүүдэлчид бэлчээрийн МАА-н зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлагууд” Малын эрүүл мэндэд тавих шаардлагын гарын авлага (Хавсралт 4),
2. “MNS 6891:2020 Хариуцлагатай нүүдэлчид бэлчээрийн МАА-н зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлагууд” Малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг, селекцид тавих шаардлагын гарын авлага (хавсралт-2),
3. “MNS 6891:2020 Хариуцлагатай нүүдэлчид бэлчээрийн МАА-н зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлагууд” стандартын гарын авлага (хавсралт-2),
4. “MNS 6891:2020 Хариуцлагатай нүүдэлчид бэлчээрийн МАА-н зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлагууд” малчны өврийн дэвтэр (хавсралт-2),
5. Хариуцлагатай Нүүдэлчид бэлчээрийн МАА-н зохистой дадал брошюр (хавсралт-2)

## Стандартыг СУРТАЛЧЛАН таниулах, сургалтын ажлын үр дүн:

Дашбалбар суманд нийт хоёр удаагийн “Хариуцлагатай нүүдэлчид” бэлчээрийн МАА-н зохистой дадлын стандартыг таниулах сургалтыг сумын ЗДТГ-н мэргэжилтэн нартай хамтран долоо болон наймдугаар сард танхимын сургалт зохион байгууллаа.

Нийт давхардсан тоогоор 50 мэргэжилтэн, 150 малчин өрх хамрагдсан байна. Түүний 64 хувь нь эмэгтэй 36 хувь нь эрэгтэй оролцогчид байлаа. Сургалтад оролцсон хүмүүсийн бүртгэлийг тайланд хавсаргав (Хавсралт 3).



*Зураг 2. Стандартын талаар мэдээлэл түгээх сургалт*

Сум тус бүрд "Илгээлтийн Эзэн" болох МБАНХ-г төлөөлөн "Хариуцлагатай нүүдэлчид" бэлчээрийн МАА-н зохистой дадлын стандартыг нэвтрүүлэхэд хяналт тавин ажиллахаар төлөөлөл ажилууллаа.

Төслийн хүрээнд Гурванзагал сумыг сонгон авч ажиллаж нийт 140 малчин, 10 сумын мэргэжилтэн нарт хоёр удаагийн сургалт өгч ажилласан боловч сумын малчид энэ стандартыг хэрэгжүүлэхэд хараахан бэлэн бус байсан тул төслийн багтай ярилцсаны дагуу Цагаан-овоо сумыг сонгон авч ажиллах болсон. Цагаан-овоо суманд МБАНХ-ны зүгээс "Хариуцлагатай нүүдэлчид" бэлчээрийн МАА-н зохистой дадлын стандартыг нэвтрүүлэхэд сургалтыг мөн хоёр удаа зохион байгуулсан. Үүнд нийт ЗДТГ-аас 25, 90 орчим малчид хамрагдсан. Цагаан-Овоо сум нь сүүлд сонгогдсон тул стандартыг нэвтрүүлэх ажлыг 9-10 сарын хооронд зохион байгуулсан.

Сургалтын хүрээнд агуулгын хувьд бэлчээрийн менежментийг сайжруулах, малын эрүүл мэнд, малын үржүүлэг селекци, малын тавлаг байдал, хоршоо бэхжүүлэх малчдын зах зээлтэй холбох хүрээнд сургалт өгсөн. Үүний үр дүнд:

**Дашбалбар сум:**

Нийт 25 малчид бэлчээр ашиглуулагчдын хэсэг байгуулан улсын бүртгэлд оруулж хамтран шинээр "Сэвсүүл жараахайн булаг" нэртэй хоршоо байгууллаа. Малчны бүлгийн бэлчээр ашиглуулах гэрээ, журмыг бэлтгэн 10 сард сумын ИНХ-аар оруулан баталгаажуулсан. Мөн энэ БАХ-дээр бэлчээрийн төлөв байдлыг хянах зорилгоор 4 улирлын фотомониторингийн судалгаа хийлээ. Малчид малын эрүүл мэнд, тавлаг байдлыг хангаж нийт 10 тон Хариуцлагатай нүүдэлчин стандартаар баталгаажсан ноолуурын гэрээ байгуулж "Snow field" ХХК өгсөн ба 200 гаруй бод малын тухайн ХХК-д нийлүүлсэн байна. Стандартаар баталгаажсан ноолуурыг үндэсний үйлдвэрт өгснөөр малчин кг дутамд 3000 төгрөгийн урамшуулал авлаа. Ингэснээр нийт хоршооны 22 малчин өрх 30 сая төгрөгийн нэмүү өртөг шингээн түүхий эдээ нийлүүлсэн байна.

**Цагаан-Овоо сум:**

Цагаан-Овоо суманд "Дорнод галуут" хоршоотой хамтран 2 болон 5-р багт ажиллахаар болж Элст боон багийн малчин өрхүүдэд хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлын бэлчээр, малын эрүүл байдал, малын тавлаг байдал, түүхий эдийн чанарыг хэрхэн хянах, хариуцлагатай малчин, байгаль орчинд ээлтэй байдлыг хэрхэн нотлох зэрэг 5 шалгуурын талаар сургалт мэдээлэл өгч ажиллалаа. Хариуцлагатай нүүдэлчид мал аж ахуйн зохистой дадлын стандартын шалгуур үзүүлэлтүүдийг хангаж баталгаажуулалтанд хамрагдаж итгэмжлэлийн гэрчилгээ авснаар хоршооны гишүүн малчин өрхөөс мал/мах бэлтгэх МҮСХ-ны хамтран зохион байгууллаа. Хамтрагч байгууллага нь шаардлага хангасан малчдын махны киллограмм тутамд 500 төгрөгийн урамшуулал нийт 382 үхэр, 737 хонь худалдан авсан. Нийт баталгаажсан малын тоо гэрээлсэн малын тооноос бага байгаа нь малын өвчин гарсантай холбоотойгоор малчид зарим малаа нийлүүлэх боломжгүй болсон. Малчид стандартыг

нэвтрүүлж үхрээ зарснаар 120 кг-н гулуузны жинтэй нэг үхрийн махнаас 130 мянган төгрөг, 22 кг гулуузны жинтэй хонины махнаас 11 мянган төгрөгийн нэмүү ашиг олох боломж бүрдсэн. Ингээснээр 2023 оны хувьд малчид 49 сая төгрөгийн ашиг үхрийн махнаас, 8.1 сая төгрөгийн нэмүү өртгийг хонины махнаас олж нийт 57.7 сая төгрөгийн нэмүү өртөг шингээн мал махаа борлуулж чадсан байна.

### Хүлээгдэж буй үр дүн 2. Сонгогдсон суманд ХАА-н түүхий эдийн хоршоо байгуулах
### Түүхий эдийн хоршоог бэхжүүлэх, чадавхжуулах

Стандартын нэвтрүүлэлтийн хүрээнд Дашбалбар суманд шинээр Хөдөө аж ахуйн түүхий эдийн худалдаа, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх, арьс, арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдааны чиглэл бүхий “Сэвсүүл Жараахайн булаг” хоршоо байгуулан стандартыг нэвтрүүлэн ажиллаж байна. Хоршооны нийт 25 малчин өрх стандартыг бүхий л шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлж байна.

Шинээр байгуулагдсан хоршоо нь түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт болоод гишүүд, засаглал хараахан бэхжээгүй байгаа тул “Илгээлтийн эзэн”-тэй хамтран хоршооны засаглалыг сайжруулах чиглэлээр сургалт өгөн ажиллаа. 2023 оны тухайд Дашбалбар сумаас гарал үүсэл тодорхой нийт 10 тон ноолуурыг бэлтгэн Япон улсын зах зээлд гаргахаар бэлтгэж байна. Мөн тухайн сумаас “Snow field” ХХК 200 гаруй бод мал худалдан авч байна. Харин Цагаан-овоо сумаас нийт 737 бог, 382 бод малыг стандарт дундын хоршоонд нийлүүлсэн.

Сэвсүүл жараахайн булаг хоршооны малчдын дунд ундны усанд болон цагаан идээ боловсруулахад ашиглаж байгаа цэнхэр сав болон бусад чанарын шаардлага хангахгүй байгаа сав суулгын хорт чанарын талаар, ундны усны ариун цэврийн талаар малчдад мэдээлэл өгч малчдын дунд цэнхэр савыг солих, хариуцлагатай нүүдэлчид стандартыг хамгийн сайн хэрэгжүүлсэн малчдын дунд 500,000 төгрөгний үнэ бүхий стандартын шаардлага хангасан айраг сүүний 140л-ын савны шагналтай уралдаан зарлаж хүлээлгэн өгсөн байна. Хоршоо нийт 25 өрхтэй ба өрх бүр 128,000 төгрөгийн хувь нийлүүлж хоршоог байгууллаа.



*Зураг 3. Малчдын дунд зарласан уралдаанд оролцогчид*

“Дорнод Галуут” хоршоо нь Монгол Улсын Өмч хувьчлалын хуулийн дагуу Цагаан-Овоо сумын Галуут нэгдэл тарахад 1992 оны 11-р сард үүсгэн байгуулагчдын санаачлагаар анх 90 гаруй өрхтэй “Галуут”ХК болон зохион байгуулагдсан юм. Үүний дараа 1998 онд УИХ-аар батлагдсан хоршооны тухай шинэ хуулиар болон Монголын ХАА-н хоршоологчдын Үндэсний холбооны V их хурлын шийдвэрийн дагуу шинэчилсэн зохион байгуулалтанд шилжиж “Дорнод Галуут” хоршоо болон бүтцийн өөрчлөлт хийж зохион байгуулагдан одоог хүртэл үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна.

Тус хоршоо нь 120 гаруй өрхтэй, 310 гаруй гишүүдтэй, 7 тэргүүлэгч, 3 хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнтэй. Хоршооны дарга, нягтлан бодогч, хоршооны удирдах зөвлөл, хоршооны малчид гэсэн бүтэцтэй. Хоршооны гишүүд амины туслах аж ахуйдаа Барга, үзэмчин, халх үүлдрийн хонийг шилэн сонгож үржүүлдэгээс гадна нутгийн хар ямаа, Баяндэлгэрийн улаан ямаагаар ноолуурын чиглэлээр нутагшуулан үржүүлж байна. Хоршооны гишүүд 100 мянган төгрөгөөр хувь нийлүүлэн ажиллаж байна.

Хоршооны малчдын өөрийн сүргээс бэлтгэдэг 1,5-2.0 тн ноолуур, 18-20 тн уртын ноос хүлээн авч борлуулалт хийсний дээр хонины ноосыг үндэсний үйлдвэрүүдэд тушааж ноосны урамшуулалд гишүүдээ бүрэн хамруулахаар журамд заасан баримтыг бүрдүүлэн өгч ажилладаг.

Түүхий эд бэлтгэлийн малчдын дундын хоршоо Малчдын хоршоог бэхжүүлэх ажлын хүрээнд Дорнод Галуут хоршоог Хариуцлагатай нүүдэлчид бэлчээрийн мал аж ахуйн зохистой дадлын стандартын дагуу баталгаажуулалтанд хамруулах, баталгаажсан хоршоогоор дамжуулан малын гаралтай бүтээгдэхүүнийг нэмүү өртөг шингэсэн зах зээлтэй шууд холбох ажлын хүрээнд 2022 онд баталгаажуулалтад хамрагдсан.

Хариуцлагатай нүүдэлчин стандартыг хэрэгжүүлснээр баталгаажуулалтад хамрагдсан Дорнод Галуут хоршооны малчин өрхөөс МҮСХ-д мал нийлүүлэх гэрээг хийхэд дэмжлэг үзүүлж малчдад урамшуулал олгох боломжийг нээж бэлчээрийн ачаалал багсаж малчдын орлого сайжрах юм.



*Зураг 4. Хоршооны малчдад нэвтрүүлэлт хийж буй нь*

### Хүлээгдэж буй үр дүн 3. Монголын хаан ширхэгт, текстилийн тогтвортой үйлдвэрлэл стандартыг нэвтрүүлэх, бүтээгдэхүүний гарал үүслийг мөшгөх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

### Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мөшгөх системийг үйлдвэрийн доторх системтэй холбож ноос, ноолууран бүтээгдэхүүнийг өртгийн сүлжээгээр нь мөшгөх боломжийг олгох

Өртгийн сүлжээг бүхлээр нь мөшгөх боломжийг олгох ажлын хүрээнд 2023 оны 10-р сарын 30-ны өдрөөс 2023 оны 11-р сарын 15-ны өдрийг дуустал “Дижитал Медик” ХХК-тай гэрээ байгуулан Хариуцлагатай нүүдэлчин бэлчээрийн МАА-н зохистой дадлын нэвтрүүлэх ажлын хүрээнд малчинд болон хоршоодод зориулсан аппликайшин хөгжүүлэж ажлыг хийлээ. Төслийн багтай ярилцсаны дагуу үйлдвэрийн доторх системийг “Дижитал Медик” ХХК-дангаараа хариуцан гүйцэтгэхээр болсон МБАНХ-зөвлөхөөр орохоор болсон.

Төслийн хүрээнд малчид стандартад хамрагдах хүсэлтээ өөрийн утаснаас илгээх боломжтой болсон ба тохирлын гэрчилгээ гарсан эсэхийг утсаараа шалгаж дараагийн урамшуулал болон бусад үйл ажилалгаанд хамрагдах боломжтой болсон. Энэ тохирлын гэрчилгээ үндэсний Дорнод галуунт хоршооны нийт 101 малчин өрх Сэвсүүл жараахайн булаг хоршооны нийт 25 өрх Хааны банкны ногоон зээлд хамрагдах боломжтой болсон.




*Зураг 5. Хариуцлагатай нүүдэлчин бэлчээрийн МАА-н зохистой дадлын стандартын систем*

## Өртгийн сүлжээний нарийвчлан боловсруулалт

Өнөөдрийн байдлаар МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг мөшгөх тогтолцоотой хэд хэд систем үүсээд байна. Үүнд малын үндэсний бүртгэлийн систем, мал эмнэлгийн нэгдсэн систем, газрын удирдлагын нэгдсэн систем, агуулах итгэмжлэлийн систем, тохирлын үнэлгээний систем. Энэхүү төслийн хүрээнд тохирлын үнэлгээний системийг бүрэн хөгжүүлж дууссан. Ингэснээр малчид утсаараа дамжуулан тохирлын хүсэлт өгөх, тохирлын гэрчилгээгээ харах, хоршооруу бүтэгдэхүүний нийлүүлэх хүсэлт өгөх гэх мэт үйл ажиллагаа бүрэн явуулах боломжтой болсон.

Мөн ШХА-н тусламжтайгаар арьс ширний үйлдвэрийн доторх систем, махны үйлдвэрийн доторх систем, сүүний үйлдвэрийн доторх систем хөгжүүлээд тухайн бүтээгдэхүүнийг малчнаас аваад хэрэглэгч хүртэл бүрэн мөшгөх боломжтой болсон. Харин ноос, ноолуурын үйлдвэрийн доторх систем хараахан хөгжүүлэгдээгүй байгаа ба АДАПТ төслийн хүрээнд хөгжүүлэгдэхээр яригдаж байна.




*Зураг 6. ХАА-н өртгийн сүлжээнд үүссэн системүүд*

ДҮГНЭЛТ

- MNS 6891:2020 Хариуцлагатай нүүдэлчид бэлчээрийн мал аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлагууд" стандартын талаар малчдад зориулсан 5 төрлийн гарын авлага бэлтгэж нийт 600 хувийг хэвлэн тараалаа.
- Давхардсан тоогоор гурван удаагийн сургалтад нийт 85 орчим засаг даргын тамгын газрын төлөөлөл, 380 орчим малчид хамрагдсан байна.
- Шинээр 2 БАХ байгуулагдсан ба Бэлчээр ашиглуулах гэрээ, журам боловсруулан ажилласан ба БАГ 12 сарын хурлаас эцэслэн улсын бүртгэлд орно.
- Дашбалбар суманд шинээр Сэвсүүл Жараахайн булаг 22 гишүүнтэй хөдөө аж ахуйн хоршоо байгуулж Монголын үндэсний стандарт дундын хоршоонд гишүүнээр элсүүллээ.
- Дашбалбар сумаас гарал үүсэл бүхий, баталгаажсан нийт 10 тон ноолуурыг Snow field ХХК-д бэлтгэн нийлүүлэн олон улсын зах зээлд гаргаж Snow field ХХК-д нийлүүлж малчид нийт 30 сая төгрөгийн нэмүү өртөг шингээж чадлаа.
- Цагааноvoo сумын Дорнод галуут хоршоонд шинээр 5 дугаар багийн малчдын Хариуцлагатай нүүдэлчин бэлчээрийн МАА-н зохистой дадлын стандартын 120 шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлж, шалгуурын дагуу үнэлгээ баталгаажуулалтын ажил явуулж тохирлын гэрчилгээ олгосноор малчид малын гаралтай түүхий эдийг өндөр үнээр борлуулах боломж бүрдсэн. Малчид стандарт нэвтрүүлээгүй үед үхрийн махыг 8 мянган төгрөгөөр, хонины махыг 6 мянган төгрөгөөр борлуулах байсан бол стандартыг нэвтрүүлж Монголын Үндэсний стандарт дундын хоршоонд Нийт 737 хонь, 382 үхэр нийлүүлсэн ба үхрийн махыг 9,5 мянган төгрөг, хонины махыг 6,5 мянган төгрөгөөр борлууллаа. өндөр үнээр борлуулж нийт 57.7 сая төгрөгийн нэмүү өртөг шингээж чадлаа. Малчид стандартыг нэвтрүүлж үхрээ зарснаар 120 кг-н гулуузны жинтэй нэг үхрийн махнаас 130 мянган төгрөг, 22 кг гулуузны жинтэй хонины махнаас 11 мянган төгрөгийн нэмүү ашиг олох боломж бүрдсэн. Ингээснээр 2023 оны хувьд малчид 49 сая төгрөгийн ашиг үхрийн махнаас, 8.1 сая төгрөгийн нэмүү өртгийг хонины махнаас олж нийт 57.7 сая төгрөгийн нэмүү өртөг олж чадсан байна.
- Малын эрүүл мэнд, тавлаг байдлыг хангаж нийт 10 тон Хариуцлагатай нүүдэлчин бэлчээрийн МАА-н зохистой дадлын стандартаар баталгаажсан ноолуурын гэрээ байгуулж "Snow field" ХХК өгсөөр малчид тухайн өдрийн ханш дээр кг дутамд 3000 төгрөгийн урамшуулал авлаа. Ингэснээр нийт хоршооны 25 малчин өрх 30 сая төгрөгийн нэмүү өртөг шингээн түүхий эдээ нийлүүлсэн байна.
- Цагаан овоо сумын Дорнод галуун хоршооны нийт 101, Дашбалбар сумын Сэвсүүл жараахайн булаг хоршооны нийт 25 малчин өрх Хариуцлагатай нүүдэлчин бэлчээрийн МАА-н зохистой дадлын стандартыг бүрэн нэвтрүүллээ.
- Хариуцлагатай нүүдэлчин бэлчээрийн МАА-н зохистой дадлын стандартыг нэвтрүүлсэн малчдад Хаан банкны Ногоон зээлийн санхүүжилтээс бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүний хөгжүүлэгдээд дуусах шатандаа явж байна. энэ бүтээгдэхүүнийг малчид Хариуцлагатай нүүдэлчин утасны апликайшнээс тохирлын гэрчилгээг банкны ажилтанд үзүүлснээр зээлд хамрагдах боломж үүсэж байна.
- Ноолуурын өртгийн сүлжээг бүрэн гүйцэт мөшгөх ажлын хүрээнд Хариуцлагатай нүүдэлчин бэлчээрийн МАА-н зохистой дадлын стандартыг малчинд зориулан хөгжүүлэх, түүнийг түүхий эдийн мөшгөх систем болох RMTS-тэй холбох ажлыг Дижитал медик ХХК-тай гэрээ байгуулан ажиллаа. Ажлын хүрээнд малчинаас үйлдвэр хүрэх бүхий л үе шатыг мөшгөх бүрэн боломжтой боллоо.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## Ноос, ноолуурын баталгаажуулалт болон тогтвортой нийлүүлэлтийг ихэсгэж, олон улсад гаргах орон нутгийн чадавхын талаарх зөвлөмж

Ноолуурын олон улсын зах зээлд Монгол улс Хаан ширхэгт стандартыг хангасан сайн чанарын нарийн ширхэгтийг нийлүүлэх бүрэн бололцоотой байгаа ч өнөөдрийн ноолуурын чанараас харахад олон улсын брэндүүдийн шаардлага нийцэх ноолуур гарахгүй байна. Тиймээс дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

- Хариуцлагатай нүүдэлчин бэлчээрийн МАА-н зохистой дадлын стандартыг төслийн сумуудад дараалан нэвтрүүлэх
- Ялангуяа ямааны чанарт суурилсан үржлийн ажлыг зохион байгуулах
- Малчдын худалдан авагч талтай холбож цаашид тогтвортой нийлүүлэх боломжийг хангах
- Одоогийн байдлаар олон улсын зах зээлд 15,5 микронтой 38-40 урттай ноолуур хамгийн өндөр үнээр борлуулагдаж байгаа тул цаашил энэ чанарт анхаарсан бодлого барих
- Монгол орон ноолуурын зах зээлд мөшгөх систем, бэлчээрийн МАА-н стандартаараа ялгарч байгаа тул ноолуурын үйлдвэрийн доторх системийг хөгжүүлэхэд анхааран ажиллах
-

*Хавсралт 1. Сэвсүүл жараахайн булаг хоршооны улсын бүртгэлийн гэрчилгээ*



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000275770

2023.08.28
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

0730001131
/ Хувийн хэргийн дугаар /

3396207
/ Регистрийн дугаар /

Сэвсүүл жараахайн булаг хоршоо — Хоршоо
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол — 01 — 2023.08.23
/ шийдвэрийн нэр / — / дугаар / — / он, сар, өдөр /

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 46200 | Хөдөө аж ахуйн түүхий эдийн худалдаа |
| 01500 | Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх |
| 14200 | Арьс, арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа |
| 46100 | Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа |

Хугацаагүй — 25 — 3,200.00
/ хугацаа / — / гишүүдийн тоо / — / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Дорнод, Дашбалбар, 5-р баг, Улз, ШТС-ын баруун талд, Утас1: 86228667, Утас2: 88202261, Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ — Б.ВОЛОРЭРДЭНЭ
/тамга/ — /гарын үсэг/

*Хавсралт 2. Системй хөгжүүлэлтийн ажлын даалгавар*

| № | Захиалагчийн ажлын даалгаврын тавигдах шаардлага | Гүйцэтгэлийн санал |
|---|---|---|
| | **Ерөнхий шаардлага:**<br>Баталгаажуулалтын систем нь Веб болон АПП хэлбэртэй байна.<br>АПП нь офлайн горимд ажиллах ба онлайн горимд шилжихэд цуглуулсан мэдээллийг серверт илгээнэ.<br>Шинжээч  АПП ашиглан газар дээрх үнэлгээг  малчны хотонд хийх тохиолдолд координатыг автоматаар тэмдэглэн мэдээллийн хамт системд илгээдэг байна.<br>Баталгаажуулалтын систем нь дараах хэрэглэгчийн эрхтэй байх ба тус бүрийн хандах эрхийн тохиргоо өөр өөр байх бөгөөд хэрэглэхэд хялбар байна.<br>Хэрэглэгч нь веб болон АПП хувилбарыг бүрэн ашиглана.<br>Админ<br>Харилцагч /малчид, хоршоод, малчдын бүлэг, сум, баг,/<br>Баталгаажуулалтын албаны захирал<br>Баталгаажуулалтын албаны мэргэжилтэн, Шинжээчид,<br>Баталгаажуулалтын зөвлөл<br>Зочин<br>Баталгаажуулалтын систем нь дараах системүүдтэй холбогдон мэдээлэл солилцох боломжтой байна.<br>RMTS (greenmongolia.mn)<br>Үйлдвэрийн доторх систем<br>Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (mofa.gov.mn)<br>МЭНС-2.0 (mahis.gov.mn)<br>Биг дата /Форм, PDF, JPG, PNG, OFFICE file гэх мэт/ цуглуулах боломжтой байх.<br>Цуглуулсан өгөгдлийг тогтмол өгөгдөлтэй харьцуулан үнэлэх боломжтой байна.<br>Цахим гэрээ хэлцэл, төлбөр тооцоо хийх<br>Тайлан болон тоон мэдээллүүдийг тохирох формат, өргөтгөлийн дагуу системээс экспортлох боломжтой байна.<br>Бичиг баримтын бүртгэлүүд нь тохирох форматын дагуу автоматаар үүсэх, бүртгэл тус бүр систем дээр системээс автоматаар дугаар авч үүснэ.<br>Багаараа ярилцаж байгаад ерөнхий шаардлагыг нэмэх магадлалтай. | Баталгаажуулалтын систем нь вэб болон АПП байх ба нүүдэлчин аппликэйшнээс хүсэлт илгээх мөн аудитын тайлан бичих боломжтой байна.<br>АПП нь офлайн горимд ажиллах ба онлайн горимд шилжихэд цуглуулсан мэдээллийг серверт илгээнэ.<br>Шинжээч нүүдэлчин апп ашиглан үнэлгээ хийхэд байршлын координатыг автоматаар тэмдэглэн мэдээллийн хамт системд илгээдэг байна.<br>Боломжтой<br>Боломжтой<br>Эзэмшигч байгууллагын албан зөвшөөрлийн дагуу дараах системүүлтэй холбогдон мэдээлэл солилцох боломжтой байна<br>RMTS (greenmongolia.mn)<br>Үйлдвэрийн доторх систем<br>Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (mofa.gov.mn)<br>МЭНС-2.0 (mahis.gov.mn)<br>PDF, JPG, PNG, OFFICE file хавсаргах боломжтой байна.<br>Боломжтой<br>Боломжтой<br>Боломжтой<br>Гэрээ, тушаал, удирдамж, төлөвлөгөө, тайлан, гэрчилгээ  гэх мэт бүртгэлүүд нь тохирох форматын дагуу автоматаар үүснэ. |

| | | |
|---|---|---|
| 1 | Бүртгүүлэх хүсэлт илгээх:<br>Хоршоо, малчдын бүлэг, хэсэг, сум, баг нь greenmongolia.mn сайтад хандан бүртгүүлэх хүсэлт илгээн баталгаажуулалтын системд хандах эрх нээлгэх.<br>Малчин “Хариуцлагатай нүүдэлчид” АПП ашиглан баталгаажуулалтын хүсэлт илгээх боломжтой байх<br>Эдгээрийг нийтэд нь харилцагч хэмээн томьёолно. | Хоршоо болон малчдын бүлэг баталгаажуулалтын систем эсвэл RMTS системээс бүртгүүлэх хүсэлт илгээнэ<br>Малчин “Хариуцлагатай нүүдэлчид” АПП ашиглан баталгаажуулалтын хүсэлт илгээх боломжтой байх |
| 2 | Шалгах:<br>Бүртгүүлэх хүсэлт илгээсэн мэдээллийг шалгаж үзсэний үндсэн дээр “хүсэлт хүлээн авах, татгалзах” гэсэн 2 товч ажиллана. | Боломжтой |
| 3 | Шалгаж үзээд “татгалзах товч дарсан тохиолдолд тайлбарын хамт мэйл хаягаар мэдэгдэл илгээнэ.<br>Шалгаж үзээд хүсэлт авах боломжтой болсон тохиолдолд системд нэвтрэх нэр, нэг удаагийн нууц үгийг бүртгүүлсэн мэйл хаягт автоматаар илгээх. | Боломжтой |
| 4 | Баталгаажуулалтын өргөдөл илгээх:<br>Харилцагч системд хэрэглэгчийн эрхээрээ нэвтрэн МБАНХ-Б-10-2021 өргөдлийн маягт -ын дагуу мэдээллийг бөглөж холбогдох материалыг бүрэн гүйцэд хавсарган илгэнэ. Илгээх үед бөглөөгүй үлдээсэн формыг бүрэн бөглөнө үү гэсэн анхааруулгыг өгөх ба дутуу бөглөсөн өргөдлийг илгээх боломжгүй байхаар тохируулна.<br>Хавсаргаж буй материалыг оруулахад PDF, JPG, PNG, OFFICE file гэх мэт өргөтгөл бүхий файлыг дэмжинэ.<br>Өөрийн үнэлгээний мэдээллийг Форм хэлбэрээр бөглөж ирүүлэх бөгөөд холбогдох нотлох материалыг PDF, JPG, PNG, OFFICE file гэх мэт өргөтгөл бүхий файлыг хавсаргах боломжтой байна. | Боломжтой |
| 5 | Өргөдлийг хүлээн авах:<br>Өргөдлийн бүртгэл системд илгээсэн цаг минутаар үүсэх бөгөөд хэрэглэгч өргөдлийн явцыг өөрийн хэрэглэгчийн эрхээр хянах боломжтой байна. | Боломжтой |
| 6 | Тохирлын үнэлгээ хийхэд бэлэн эсэхэд дүн шинжилгээ хийх:<br>Баталгаажуулалтын мэргэжилтэн өргөдлийн материалыг цааш дэлгэрүүлэн харах бөгөөд | Татгалзах болон хүлээн авах үйлдэлтэй байх.<br>Тодруулгыг аман байдлаар авах нь тохиромжтой, Аль нэг бичиг баримт |

| | | |
|---|---|---|
| | өргөдлийн материалд дүн шинжилгээ хийж “Нэмэлт тодруулга авах”, “Татгалзах”, “Хүлээн” авах гэсэн товчийг ашиглах хариу үйлдэл үзүүлнэ.<br>Нэмэлт тодруулга авах товчийг дарснаар тодруулга авах цонх үүсэх бөгөөд авах тодруулгыг дэлгэрэнгүй бичиж илгээнэ.<br>Хүлээн авах товчийг дарснаар харилцагчтай гэрээ байгуулах эрх үүснэ.<br>Татгалзах товчийг дарахад тайлбар оруулах цонх үүсэх бөгөөд шалтгааныг тайлбарлан оруулна.<br>Дээрх гурван товчийг дарахад харилцагчид тухайлсан сануулгууд албан бичгийн загвар дээр ирнэ.<br>Хэрэглэгчид өөрт тохирсон хязгаарлагдмал эрхийн хүрээнд өргөдлийн явцыг хянана. | зөрүүтэй эсвэл дутуу гэж санагдвад татгалзах дарахдаа тайлбар бичин буцаана<br>Хүлээн авах товчийг дарснаар харилцагчтай гэрээ байгуулах эрх үүснэ.<br>Татгалзах товчийг дарахад тайлбар оруулах цонх үүсэх бөгөөд шалтгааныг тайлбарлан оруулна.<br>Өргөдлийг хүлээн авах эсвэл татгалзсан мэдэгдэл захиалагчид албан бичгээр бус имэйлээр мэдэгдэл байдлаар илгээгдэнэ.<br>Хэрэглэгчид өөрт тохирсон хязгаарлагдмал эрхийн хүрээнд өргөдлийн явцыг хянана. |
| 7. | Баталгаажуулалтын гэрээ байгуулах:<br>Баталгаажуулалтын гэрээг “МБАНХ-Б-02-2023 Баталгаажуулалтын гэрээ” -ний загварыг ашиглана.<br>Гэрээ байгуулах эрх үүссэн харилцагчтай тохирлын үнэлгээ баталгаажуулалтын гэрээг байгуулна.<br>Гэрээг хоёр тал баталгаажуулж төлбөр бүрэн төлөгдсөнөөр албажна. | Боломжтой |
| 8 | Гэрээ бүртгэх:<br>Баталгаажуулалтын мэргэжилтэн Баталгаажсан гэрээг бүртгэж гэрээ бүртгэгдсэн төлөвт шилжинэ. | Боломжтой |
| 9 | Шинжээчийн багийн бүрэлдэхүүнийг танилцуулж санал авах<br>Баталгаажуулалтын албаны дарга томилох харилцагчид шинжээчийн багийн бүрэлдэхүүнийг танилцуулж цахим санал авна. “Томилох шинжээчийн багийг танилцуулж санал авах хуудас” -ыг ашиглана. | Гэрээгээр шийдэгдэнэ |
| 10 | Багийн бүрэлдэхүүнтэй танилцаж санал өгөх.<br>Шинжээчийн багийн бүрэлдэхүүнтэй танилцаж ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзвэл татгалзах зүйлгүй талаар саналаа буцаан мэдэгдэнэ. | Гэрээгээр шийдэгдэнэ |
| 11. | Тохирлын үнэлгээний хамрах хүрээг тодорхойлж, шинжээчийн багийн ахлагч, гишүүдийг томилох: | Боломжтой.<br>Боломжтой<br>Харилцагчаас бусад системийн хэрэглэгч аудит цонх руу нэвтрэхэд шударга |

| | | |
|---|---|---|
| | Тохирлын үнэлгээний хамрах хүрээг сонгоно. Шинжээчийн багийн бүрэлдэхүүн болон ахлагчийг томилж тушаал гарган. Тушаалыг хавсаргана /PDF/<br>Томилогдсон шинжээчид, багийн ахлагч тус бүрийн эрх нээгдэнэ. Багийн ахлагч болон гишүүд тус бүр шударга байдлын мэдэгдэлтэй танилцаж зөвшөөрөх товчийг дарж илгэнэ. | байдлын мэдэгдэл текст бүхий сануулга цонх гарч ирэх ба түүнийг чеклэнэ. |
| 12 | Тохирлын үнэлгээ баталгаажуулалтын ажлын эхлүүлнэ.<br>Шинжээчийн багийн ахлагчид тохирлын үнэлгээнд хамрах хоршооны мэдээллийг бүрэн харах боломжтой болно.<br>Багийн ахлагч харилцагчтай анхны холбоо барих /энэ нь системээс гадуур байж болно. | Боломжтой |
| 13 | Ажлын удирдамж төлөвлөгөө боловсруулах.<br>МБАНХ-Б-14-2021 Ажлын удирдамж, МБАНХ-Б-15-2021 Төлөвлөгөө "<br>Багийн ахлагч нь дээрх 2 загварын дагуу удирдамж, төлөвлөгөөг систем дээр үүсгэж бүртгээд батлуулахаар илгээх болон ноороглож болно. | Удирдамж төлөвлөгөөг систем дээр үүсгэх боломжтой. Батлах үйлдэл хийгдэхгүй. |
| 14 | Удирдамж төлөвлөгөөг батлах:<br>Захирал шинжээчийн багийн ахлагчийн илгээсэн удирдамж төлөвлөгөөтэй танилцаж "Батлах" болон "татгалзаж залруулах санал илгээх" товчийг аль болохыг сонгоно. | Төлөвлөгөө, удирдамж, тушаалийг хэрэглэгчид нээлттэй харуулах байдлаар шийднэ |
| | Татгалзах:<br>Захирал "Татгалзаж залруулах санал илгээх" товчийг дарснаар залруулах сануулга багийн ахлагчид илгээгдэнэ. Энэ тохиолдолд багийн ахлагч ажлын удирдамж, төлөвлөгөөг засаж залруулаад батлуулахаар дахин илгээнэ | Захиралын эрхээр удирдамж, тушаал үүсгэнэ. |
| 16 | Батлах:<br>Захирал "Батлах" товчийг сонгосноор шинжээчийн багийн ахлагч гишүүдэд ажил хуваарилах эрх үүснэ. | Багийн гишүүд томилох үйлдэл нь хэзээд нээлттэй байх |
| 17 | Шинжээчийн багийн гишүүдийн ажлыг хуваарилах<br>Багийн ахлагч томилогдсон шинжээч нарын ажлыг хуваарилж мэдээллээр хангана. | Багийн ахлагч төлөвлөгөө гаргаж ажлыг хуваарилах. Шинжээч нар төлөвлөгөөтэй танилцах боломжтой байх. |
| 18 | Ажлын баримт бичиг боловсруулах:<br>Гишүүд тус бүр өөрт оногдсон тохирлын үнэлгээний хамраах хүрээний дагуу баримт бичгийг боловсруулна. | Гишүүд тус бүр өөрт оногдсон тохирлын үнэлгээний хамраах хүрээний дагуу баримт бичгийг боловсруулна. |

| | | |
|---|---|---|
| | Хоршооны баримт материалтай танилцаж үнэлгээнд хамрагдах өрхийг санамсаргүй түүврийн аргаар сонгоно.<br>Нээлтийн хурлын тэмдэглэл<br>Ажиглалтын хуудас<br>Шалгах хуудас-<br>Үл тохирлын тэмдэглэл<br>Хаалтын хурлын тэмдэглэл<br>Аудитын тайлангийн загвар | Санамсаргүй түүврийн аргаар сонгосон өрхийг аудитын тайлан бүртгэх хэсэгт бүртгэнэ<br>Хурлын тэмдэглэлийг тайлан бичих хэсэгт бичнэ<br>Ажиглалтын мэдээллийг тайлан хэсэгт бичнэ<br>Шалгах хуудасны асуултыг стандартын шалгуур үзүүлэлт бүрт тохируулах.<br>Тайланд асуулгын хариултууд харагдана.<br>Үл тохиролыг бичих боломжтой<br>Тэмдэглэл бичих боломжтой<br>Тайланг зарварын дагуу оруулах |
| 19 | Багийн гишүүд өөрт ноогдсон ажлын хүрээнд мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх ба аудитын нотолгоог бүртгэж, иш татахад шаардлагатай ажлын баримт бичгийг бэлтгэнэ.<br>Хөндлөнгийн үнэлгээнд хамрагдах гишүүдийн шаардлагатай мэдээллийг шинжээч тус бүр холбогдох мэдээллийн сангуудаас татах.<br>Харилцагчтай холбогдож тохирлын үнэлгээний хамрах хүрээ шаардлага тус бүрээр нотолгоо мэдээлэл цуглуулах. | Харилцагчтай холбогдож тохирлын үнэлгээний хамрах хүрээ шаардлага тус бүрээр нотолгоо мэдээлэл цуглуулж, аудитын нотолгоог бүртгэж, иш татахад шаардлагатай ажлын баримт бичгийг хавсаргана |
| 20 | Газар дээрх тохирлын үнэлгээний ажлыг гүйцэтгэх:<br>Нээлтийн хурал хийх ба хурлын тэмдэглэлийг хөтөлж системд бүртгэнэ.<br>Нээлтийн хурлын үеэр үнэлгээний явцад харилцах хөтөч болон ажиглагчийн үүрэг, хариуцлагыг хуваарилах<br>Шинжээч тус бүр урьдчилан боловсруулсан шалгах хуудны дагуу системийн АПП хувилбарыг ашиглан үнэлгээ хийх, мэдээлэл цуглуулах ба шалгах<br>Үнэлгээний үр дүнг гаргах хамрах хүрээ тус бүрээр гаргана.<br>Хөндлөнгийн үнэлгээний урьдчилсан үр дүнг гаргаж хаалтын хурлын үеэр танилцуулна. Хаалтын хурлын тэмдэглэл,<br>Үнэлгээний урьдчилсан үр дүн,<br>Сайн туршлага<br>Шалгуурт тохирч байна<br>Шалгуурт тохирч байна гэхдээ сайжруулах боломжтой<br>Шалгуурт үл тохирч байна-Жижиг үл тохирол,<br>Шалгуурт үл тохирч байна-Том үл тохирол | Системд хурлын тэмдэглэлийг гараас оруулна<br>Шинжээч тус бүр урьдчилан боловсруулсан шалгах хуудасны дагуу системийн АПП хувилбарыг ашиглан үнэлгээ хийх, мэдээлэл цуглуулах ба шалгах<br>Үнэлгээний үр дүнг бүртгэнэ<br>Хаалтын хурлын тэмдэглэл бичих, тайлантай танилцах боломжтой байна |

| | | |
|---|---|---|
| 21 | Үл тохирол:<br>Үнэлгээний явцад том жижиг үл тохирол илэрсэн тохиолдолд харилцагчид мэдэгдэнэ. | Үнэлгээний тайлан хүсэлт гаргагчид илгээгдэнэ |
| 22 | Том үл тохирол:<br>Үл тохирлын бүртгэл үүсгэнэ.<br>Тохирлын үнэлгээний ажлыг гүйцэтгэхээс татгалзах мэдэгдэл хүргүүлнэ. | |
| 22 | Жижиг үл тохирол:<br>Үл тохирлын бүртгэл үүсгэнэ.<br>Үл тохирлыг залруулах санал илгээнэ. | Үнэлгээний тайлан хүсэлт гаргагчид илгээгдэнэ. Тайлан дээр үл тохиролын мэдээлэл саналын хамт харагдана |
| 23 | Залруулах арга хэмжээний төлөвлөгөө, тайланг бэлтгэж, аудитын багт хүргүүлэх :<br>Үл тохирол тус бүрээр залруулах хугацааг тогтоож тэмдэглэл оруулна.<br>Төлөвлөгөөний дагуу залруулсан хэрэгжүүлсэн арга хэмжээг үл тохирлын тэмдэглэлд бүртгэж нотлох баримтыг холбогдох форматаар файл болгон хавсарган | Боломжтой |
| 24 | Тохирлын үнэлгээний нэгдсэн тайланг үүсгэж баталгаажуулалтын зөвлөлд илгээх<br>Багийн ахлагч тохирлын үнэлгээний тайланг нэгдсэн тайланг системд үүсгэн хянан баталгаажуулна.<br>Шинжээчийн багийн гишүүн тус бүрийн тохирлын үнэлгээний үр дүнг нэгдсэн тайланд хавсралт мэдээллийн хамт дуудна.<br>Харилцагчийн холбогдох мэдээлэл болон өгөгдөл нь автоматаар тайлангийн форматын дагуу бөглөгдөнө<br>Багийн ахлагч Нэгсэн дүгнэлтийг тайланд оруулна.<br>Тайланг хянаж эцэслэсний дараа баталгаажуулалтын зөвлөлд илгээнэ. | Боломжтой |
| 25 | Шинжээчийн багийн тайлан дүгнэлттэй танилцаж санал өгөх, хэлэлцэх:<br>Хурлын товыг зөвлөлийн хурал даргалагч товлоно хулыг google meet болон ZOOM платформ ашиглан цахимаар хийх бөгөөд урьдчилан саналын хуудас илгээсэн тохиолдолд зөвлөлийн гишүүнийг хуралд оролцсонд тооцно.<br>Тайланг танилцуулна.<br>Зөвлөлийн гишүүн тус бүр тайлантай танилцаж саналын хуудас бөглөнө.<br>Саналын хуудсыг илгээнэ | Зөвлөлийн гишүүдийг сонгон тайланг илгээнэ<br>Зөвлөлийн гишүүн бүр өөрийн эрхээр орон тайлантай танилцаж, саналаа өгөх боломжтой байна<br>Хуралд оролцогчдын 66,6 хувь нь дэмжсэн тохиолдолд тайлан баталгаажна. |

| | | |
|---|---|---|
| | Хуралд оролцогчдын 66,6 хувь нь дэмжсэн тохиолдолд тайлан баталгаажна. | |
| 26 | Дахин хянах:<br>Зөвлөлийн гишүүдийн 34 хувь болон түүнээс дээш хувь нь татгалзсан тохиолдолд тайланг дахин хянаж зөвлөлд дахин илгээнэ. | Боломжтой |
| 26 | Тайлан баталгаажсан:<br>Харилцагчтай тохирлын гэрчилгээний шийдвэрийг танилцуулж гэрчилгээ хэрэглэх гэрээг байгуулж баталгаажуулна.<br>Баталгаажуулалтын албаны захирал шинжээчийн багийн хөндлөнгийн үнэлгээний тайлан, баталгаажуулалтын зөвлөлийн санал үндэслэн гэрчилгээг эхний удаад 2 жилээр олгоно. Хэвлэмэл /үнэт цаас/ болон цахим<br>Цахим гэрчилгээг RMTS -д хоршооны мэдээлэлд хавсралтын хамт харуулна.<br>Гэрээ болон гэрчилгээний бүртгэл үүснэ. | Гэрчилгээ үүсгэх эрхтэй хэрэглэгч гэрчилгээг тохирох хугацааны дагуу үүсгэх<br>Цахим гэрчилгээг RMTS -д хоршооны мэдээлэлд хавсралтын хамт харуулна.<br>Гэрээ болон гэрчилгээний бүртгэл үүснэ |
| 27 | Гэрээ байгуулж гэрчилгээ олгосноос хойш 12 сар тутамд магадлах үнэлгээг гүйцэтгэнэ:<br>Магадлах аудитыг гүйцэтгэх хугацаа гэрээ байгуулж гэрчилгээ олгосноос хойш 12 сар болсны дараа нээгдэнэ. | Боломжтой |
| 28 | Харилцагчийн хүсэлтээр Гэрээ гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас өмнө дээрх схемийн дагуу баталгаажуулалтын ажлыг дахин шинээр эхлүүлнэ. | Боломжтой |

*Хавсралт 3. Дашбалбар сумын өнөөгийн нөхцөл байдал*

| Д/д | Сул тал | Давуу тал |
|---|---|---|
| **1** | Гадны мал ихээр орж ирэх болсон нь бэлчээр муутгаж, хадлан авах боломжгүй болгож байна.<br>Малчид нүүдэл сэлгээ хийх нь багасаж илүү суурьшмал хэлбэр лүү шилжиж байна.<br>Зуны улиралд зарим айл өвөлжөөний бэлчээр рүү малаа оруулж идүүлж байна<br>Сүүлийн жилүүдэд ердийн хөсөг ашиглахаа больж мотоцикл, машинаар нүүдэл хийх, мал хариулах зэргээр бэлчээрт сөхөн нөлөө үзүүлж байна<br>Хоршооны муу туршлага бий болсноос малчид хоршиж хамтрахад болгоомжилж байна. | Бэлчээр нь харьцангуй соргог төлөв байдалд байна,<br>Сумын ихэнх малчдаас жил бүр Снөөв Фийлдэс ХХК ноолуурыг авч хэвшсэн байна,<br>Хариуцлагатай нүүдэлчид стандартыг нэвтрүүлэх сонирхлоо ихэнх нь илэрхийлж байна.<br>Ил задгай нуур, цөөрөм, хужир мараа элбэг<br>Ихэвчлэн байгалийн хадлан бэлтгэж хангалттай хэмжээнд нөөцөлдөг<br>Малаас авч байгаа өнөөгийн ашиг шимийн гарц стандартад заасан үзүүлэлтээс илүү байна. |

Малын тоо нэмэгдэж байгаа нь бэлчээрийг доройтуулах эрсдэлийг бий болгож байна. Нэгдүгээр багт бэлчээрийн даац хэтэрсэн,

Мэргэжлийн мал зүйч сумдад байхгүй

Удам гарваль тодорхойгүй эцэг малыг үржилд их ашиглаж байгаа

Үржлийн малд хяналт байхгүй

2021 онд үхрийн арьс товруутах, цэцэг, шүлхий өвчин гарч байсан.

Хувийн мал эмнэлэг үржлийн (МЭҮН) 4 нэгжтэй. Малын эмчийн хүрэлцээ муу байна. Залуу эмч нар суманд ажиллах сонирхолгүй байна

2021 онд үхрийн арьс товруутах, цэцэг, шүлхий өвчин гарч байсан.

Өмнө халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх ажлыг жилд олон удаа хийж байгаагүй

Үхрийн арьс товруутах өвчин гарахад тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах туршлага байгаагүй. Мөн МЭЕГ-аас өвчтэй малыг устгах, устгахгүй гэх зааварчилгаа маш их удаж ирсэн. Үүнээс болж халдвар тархах гол шалтгаан болсон.

Яс сөнөрөх өвчнийг оношлох, эмчлэх арга зүйгүй байхад жил олон тооны мал тус өвчнөөр хорогдож байсан

Малчид малын эмийн зөв зохистой хэрэглэх тал дээр ойлголт муутай байна.

Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ авахдаа малын эмчид үзүүлэхгүйгээр авдаг

Ноолуур болон ноосоо өнгөөр нь болон насаар нь ангилан ялгаж зах зээлд борлуулдаггүйг.

Түүхий эдийн буюу малчдын хоршоо байхгүйгээс түүхий эдээ бөөн дүнгээр үнэтэй өгөх боломжийг алдаж байна.

Ноос, ноолуураас өөр малын гаралтай түүхий эдийн орлого муу.

МЭҮН нь ажил үйлчилгээгээ цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэж байгаа талаар сумын ЗДТГ-аас тодорхойлж байсан.

2022 оны 8 дугаар сарын байдлаар мал, амьтны халдварт, гоц халдварт өвчин бүртгэгдээгүй тайван байна.

Сумын мал эмнэлгийн тасаг болон МЭҮН-үүд 3 дахь удаагийн үзлэгт мал сүргээ бүрэн хамруулсан байна.

Шүлхий, үхрийн арьс товруутах, цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад мал, сүргээ бүрэн хамруулсан

Өнгөрсөн 3 жил аймгийн хэмжээнд зуншлага сайхан болж үхрийн яс сөнөрөх өвчний гаралт бага байгаа талаар аймгийн МЭГ-аас мэдээлж байсан. Аймгийн хэмжээнд тус өвчнийг газар дээр нь оношлох зөөврийн цусны биохимийн аппараттай болсон.

Гэрээт малын эмчээс шаардлагатай эм, тариа авдаг.

Мал эмнэлгийн цахим нэгдсэн системд холбогдсон. Мал, амьтны шилжилт хөдөлгөөн болон түүхий эдэд QR код бүхий гарал үүслийн бичгийг цаг алдахгүй олгох боломж бүрдсэн. Мөн мал эмнэлгийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус арга хэмжээг цахим бүртгэлийн системээр дамжуулан малчны хотонд хүрч үйлчилж байна

Ноолуурын чанар сайн буюу нарийн микронтой ноолууртай.

Ноос цагаан өнгийн, нарийн ноостой.

*Хавсралт 4. Гарын авлага материал*















*Хавсралт 5. Сургалтын бүртгэл*

| | | | |
|---|---|---|---|
| **07/02 Баян-Уул сум** | | | |
| 1 | 10:00-10:10 | Хариуцлагатай нүүдэлчин МАА-н зохистой дадлыг нэвтрүүлэхэд орон нутгийн оролцоо, хамтын ажиллагаа | Сумын засаг дарга |
| 2 | 10:10-10:30 | Төслийн танилцуулга, Хариуцлагатай нүүдэлчин стандарт | Д.Булгамаа |
| 3 | 10:30-11:00 | Хариуцлагатай нүүдэлчин МАА-н зохистой дадлын шалгуу үзүүлэлтүүд: Бэлчээр, бэлчээрийн төлөв байдал | Д.Булгамаа |
| 4 | 11:00-11:30 | Хариуцлагатай нүүдэлчин МАА-н зохистой дадлын шалгуу үзүүлэлтүүд: Малын эрүүл мэнд | Б.Баасанжаргал |
| 5 | 11:30-12:00 | Хариуцлагатай нүүдэлчин МАА-н зохистой дадлын шалгуу үзүүлэлтүүд: Малын үржүүлэг селекцид | Т.Ариунболд |
| 6 | 12:00-12:30 | Хариуцлагатай нүүдэлчин МАА-н зохистой дадлын шалгуу үзүүлэлтүүд: Малын арчиллагаа маллагаа | Т.Ариунболд |
| 7 | 12:30-13:00 | Хариуцлагатай нүүдэлчин МАА-н зохистой дадлын шалгуу үзүүлэлтүүд: Түүхий эдийн чанар | Э.Анхбаяр |
| **07/03 Дашбалбар сум** | | | |
| 1 | 10:00-10:10 | Хариуцлагатай нүүдэлчин МАА-н зохистой дадлыг нэвтрүүлэхэд орон нутгийн оролцоо, хамтын ажиллагаа | Сумын засаг дарга |
| 2 | 10:10-10:30 | Төслийн танилцуулга, Хариуцлагатай нүүдэлчин стандарт | Д.Булгамаа |
| 3 | 10:30-11:00 | Хариуцлагатай нүүдэлчин МАА-н зохистой дадлын шалгуу үзүүлэлтүүд: Бэлчээр, бэлчээрийн төлөв байдал | Д.Булгамаа |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | 11:00-11:30 | Хариуцлагатай нүүдэлчин МАА-н зохистой дадлын шалгуу үзүүлэлтүүд: Малын эрүүл мэнд | Б.Баасанжаргал |
| 5 | 11:30-12:00 | Хариуцлагатай нүүдэлчин МАА-н зохистой дадлын шалгуу үзүүлэлтүүд: Малын үржүүлэг селекцид | Т.Ариунболд |
| 6 | 12:00-12:30 | Хариуцлагатай нүүдэлчин МАА-н зохистой дадлын шалгуу үзүүлэлтүүд: Малын арчиллагаа маллагаа | Т.Ариунболд |
| 7 | 12:30-13:00 | Хариуцлагатай нүүдэлчин МАА-н зохистой дадлын шалгуу үзүүлэлтүүд: Түүхий эдийн чанар | Э.Анхбаяр |

*Хавсралт 6. Сургалтын хөтөлбөр*

| **08/05 Баян-Уул** | | | |
|---|---|---|---|
| 1 | 09:00-10:00 | Баян-Уул сумын Засаг дарга, ХАА мэргэжилтэн, МАА мэргэжилтэн, Бэлчээрийн мэргэжилтэн, Малын эмч-тэй уулзах, төслийн хүрээн дэх хамтын ажиллагааны үндсэн чиглэл, уулзалтын хөтөлбөр танилцуулах | МБАНХ-ны баг |
| 2 | 10:00-11:00 | Бэлчээр, малын эрүүл мэнд зэрэг Хариуцлагатай нүүдэлчид стандартыг танилцуулах | МБАНХ Д.Бурмаа, зөвлөх |
| 3 | 11:00-11:30 | Хэлэлцүүлэг, Баталгаажуулалтын тухай ойлголт | Д.Бурмаа |
| 4 | 11:40-13:00 | Асуулт, хариулт | |
| 5 | 14:00-14:20 | Зорилтот хоршооны малчдын төлөөлөлтэй хамтарч ажлын төлөвлөгөө, оролцогч талууд, хүлээгдэх үр дүн, малчдын оролцооны талаар зөвлөлдөх , нэгдсэн зураглал гаргах | МБАНХ, Зөвлөхүүд |
| 6 | 14:30-18:00 | Хоршооны гишүүдтэй уулзах уулзалт | МБАНХ, Зөвлөхүүд |
| **08/06 Дашбалбар** | | | |
| 1 | 09:00-10:00 | Дашбалбар сумын Засаг дарга, ХАА мэргэжилтэн, МАА мэргэжилтэн, Бэлчээрийн мэргэжилтэн, Малын эмч-тэй уулзах, төслийн хүрээн дэх хамтын ажиллагааны үндсэн чиглэл, уулзалтын хөтөлбөр танилцуулах | МБАНХ-ны баг |
| 2 | 10:00-11:00 | Бэлчээр, малын эрүүл мэнд зэрэг Хариуцлагатай нүүдэлчид стандартыг танилцуулах | МБАНХ Д.Бурмаа |
| 3 | 11:00-11:30 | Хэлэлцүүлэг, Баталгаажуулалтын тухай ойлголт | Д.Бурмаа |
| 4 | 11:40-13:00 | Асуулт, хариулт | |
| 5 | 14:00-14:20 | Зорилтот хоршооны малчдын төлөөлөлтэй хамтарч ажлын төлөвлөгөө, оролцогч талууд, хүлээгдэх үр дүн, малчдын оролцооны талаар зөвлөлдөх , нэгдсэн зураглал гаргах | МБАНХ, Зөвлөхүүд |
| 6 | 14:30-18:00 | Хоршооны гишүүдтэй уулзах уулзалт | МБАНХ, Зөвлөхүүд |